МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 26 өдөр Дугаар А/174 Мөрөн сум

Захирамжийн хавсралтад нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/44 дүгээр захирамжийн хавсралтад дараах нэмэлт өөрчлөлт оруулсугай. Үүнд:

1.1.1. Захирамжийн хавсралтын 19 дэх мөрөнд "Төсөл арга хэмжээний нэр" гэсэн хэсгийн "04 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих зураг төсөв /Мөрөн сум/"-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэр хүрэхгүйн улмаас төсөвт өртөг нь дутуу батлагдсан байх тул "Олгох эх үүсвэр" нь "7,678,486" гэснийг "23,199,181" гэж нэмэлт өөрчлөлт оруулсугай.

1.1.2. Захирамжийн хавсралтын 26 дахь мөрөнд "Төсөл арга хэмжээний нэр" гэсэн хэсгийн "Рашаант сумын ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засварын ажлын зураг төсөв"-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээнд зарцуулах хөрөнгийн гэрээний үнийн дүнг алдаатай баталсан байх тул "Олгох эх үүсвэр" нь "19,500,000" гэснийг "19,850,000" гэж нэмэлт өөрчлөлт оруулсугай.

1.1.3. Захирамжийн хавсралтын 9 дэх мөрөнд "Төсөл арга хэмжээний нэр" гэсэн хэсгийн "Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын барилгын ажлын зөвлөх"-ийн зургийн ажлаа бүрэн гүйцэтгээгүй, зураг төсвөө хүлээлгэж өгөөгүй байгаа тул "Олгох эх үүсвэр" нь "18,850,000" гэснийг "13,579,305" гэж өөрчилсүгэй.

1.1.4. Захирамжийн хавсралтын 7 дахь мөрөнд "Төсөл арга хэмжээний нэр" гэсэн хэсэгт заасан "Хөгжимт драмын театрын барилгын 14-18 тэнхлэгийн шугаман суурийг хүчитгэх, шинэчлэх ажлын зураг төсөв"-ийг боловсруулахаар шалгарсан зөвлөх үйлчилгээг гүйцэтгэгч байгууллага нь гэрээгээ байгуулаагүй, зураг төсвийн ажлыг гүйцэтгэх боломжгүй болсон тухай албан бичгээр мэдэгдсэн байх тул тус мөрийг хассугай.

2. Дээрх өөрчлөлт орсон төсөл арга хэмжээнүүдийн санхүүжилтийн баримт бичгийн бүрдлийг хангаж хууль тогтоомжийн хүрээнд зураг төсвийн сангийн шилжих хөрөнгө оруулалтаас гаргаж зарцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022